# Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт

2024 оны 12 дугаар сарын 03

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөвт өртөг | Санхүүжих дүн | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Аймгийн Хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ | 20,967,28 | 9,873,11 | Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн | 85% | Барилгын ажлыг бүрэн дуусгана. | "Акми холдинг" ХХК тендерт шалгарч 2013 оны 07 дугаар сард эхлүүлж үндсэн каркас угсралтын ажил, дотор, гадна ханын дүүргэлт, цахилгааны монтаж, цонх суулгах, дотор ханын шаврын ажил, дээврийн ажлууд хийгдсэн, мөн гадна дулаан, бохир усны ажлууд хийгдсэн дотор заслын ажлууд болон гадна фасадын ажил хийгдэж байгаад 2021 оны 11-р сард ажил зогссон тул гүйцэтгэгч байгууллагыг сольж Соёлын яамнаас 2023 онд үлдэгдэл ажилд дахин тендер зарлан “Батс-Өргөө” ХХК шалгарч 2024 онд ажлыг эхлүүлэн 2024 оны байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй 2024 онд багтаан барьж дуусгахаар ажиллаж байна. | 90 |
| 2. | Солийн Данзангийн нэрэмжит Музей, цэцэрлэгт хүрээлэн /Хотонт сум/ | 1.141.00 | 205.90 | Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн | 70 | Барилгын ажлыг бүрэн дуусгана. | Солийн Данзангийн нэрэмжит Музей, цэцэрлэгт хүрээлэнгийн барилгыг шинээр барихаар 2019 онд 1,141.0 сая төгрөг батлагдаж тус барилгын ажлыг “Жоншт констракшн" ХХК 2020 онд тендерт шалгарч барилгын ажлыг эхлүүлсэн одоогоор барилгын ажил 98 хувьтай тус барилгыг 2024 онд багтаан хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | 95 |
| 3. | Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилга /Эрдэнэбулган сум/ | 4,075,30 | 3,325,30 | Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн | 5% | Барилгын ажлыг 30 хувьд хүргэнэ. | Барилга баригдах байршил солигдсоны улмаас суурин холболт, ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж баталсан. Тендерт шалгарсан "ЭНИГМА" ХХК нь барилгын суурь цутгалтын ажлыг эхлүүлэн ажиллаж байна. | 30 |
| 4. | Соёлын төвийн барилга /Архангай, Өгийнуур сум/ | 4,231,90 | 1,269.57 | Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн | 0 | 1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна. | Өгийнуур сумын Соёлын төвийн барилга нь 1965 онд ашиглалт орсон одоогоор үйл ажиллагаа явуулах боломжгүй гэж Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2.Гүйцэтгэлийг 30 хувьд хүргэнэ. | Тус соёлын төвийн барилгыг 2024-2026 онд шинээр барихаар төлөвлөж төсөвт 4,231.9 сая төгрөг батлагдсанаас 2024 онд 1,269.5 сая төгрөгийн төсөв батлагдсан.<br>Барилгын зураг төсвийг “Зэт Фрожикт” ХХК хийж гүйцэтгэсэн. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас тендерийг зарлаж “Очир-Өргөө” ХХК шалгарсан. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар суурь цутгалтын ажлыг эхлүүлсэн байна. | |
| 5. | Угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг нийт өрхийн дунд үе шаттайгаар зохион байгуулах | Батлагдсан төсөв | хувь | Шинээр тооцно | 15 | 30 | “Монголчуудын угийн бичгийн академи”-ийн Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтнийг “Угийн бичиг хөтлөлтийн арга зүй” сэдэвт сургалтад 2024 оны 04 дүгээр сард хамруулсан.<br>Сумдын Соёлын төвийн Номын санчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд аймгийн Нийтийн номын санд зохион байгуулсан бөгөөд тус сургалтад угийн бичиг хөтөлж хэвших ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдол” сэдвээр хичээл орж, гарын авлагаар хангав.<br>Эрдэнэбулган сумын угийн бичиг хөтөлдөг 25 өрхийн төлөөллийн туршлага солилцох уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр аймгийн Нийтийн номын санд зохион байгуулсан.<br>Аймгийн хэмжээнд угийн бичиг хөтөлдөг өрх 2023 онд 99 байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 33 өрх шинээр хөтөлж эхэлсэн байна.<br>Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "Соёл урлагийг дэмжих хөтөлбөр" дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд угийн бичиг хөтлөх өрх, иргэнийг нэмэгдүүлэх, урамшуулах, сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар тусган ажиллаж байна. | 90 |
| 8 | Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан соёлын бүтээлч | Улс, Орон | Баримт бичиг | - | Батлагдсан төлөвлө | Улс, Орон | 2024 оны 07 дугаар сарын 16-17-нд Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэнг Монгол Солонгосын соёлын өдрүүд арга | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэлийн зураглал, стратеги боловсруулах | нутгийн төсөв | батлагдсан байна. | | гөө - 1 Хэрэгжилтийн тайланг Соёлын яаманд ирүүлсэн байна. | нутгийн төсөв | хэмжээний үеэр зохион байгуулж соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зураглал, стратеги боловсруулах төлөвлөгөөний саналыг авч боловсруууллаа. | |

ХЯНАСАН: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.АВАРЗАД

ТАЙЛАН БИЧСЭН: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ СТАТИСТИК МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.ХОНГОРЗУЛ